

344



**МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216. Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
М.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА**

2020.10.20 № 0111873  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Төлөвлөгөөний төсөл хүргүүлэх тухай**

Танд энд өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга нар Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаатай танилцсан билээ.

Энэ үйл ажиллагаанд цахимаар оролцсон Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, гишүүдэд Байнгын хороодын дарга нараас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл хүргүүлж байна.

Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг яам, агентлаг болон нийслэл, орон нутгийн захиргааны байгууллагуудын онцлогт тохирсон ажлуудыг багтаан баталж, биелэлтийн тайланг 2020 оны 12 дугаар сарын 25-ны дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлнэ үү.

Та бүхний хамтын ажиллагааны үр дүнд төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, цахим системийг хөгжүүлэхэд ахиц дэвшил гарах юм.

ДАРГА




Б.БААТАРЗОРИГ

20004833

Төрийн албаны зөвлөлийн  
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн  
01/18.7.3 дугаартай албан бичгийн хавсралт

УИХ-ЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН, ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БОЛОН  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА НАРААС  
ӨГСӨН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ



д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцан хэрэгжүүлж, тайлагнах байгууллага, албан тушаалтан	Биелэлт, явцын мэдээ ирүүлэх хугацаа
1	Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга нар	2020.12.25
2	Хуулийн засаглал, сахилга хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч ажиллах		2020.12.25
3	Цахим засаглалыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг үр ашигтай, шударга, ил тод болгоход санаачлагатай, үр дүн гаргаж ажиллах		2020.12.25
4	Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд зохион байгуулж байгаа сургалт зөвлөгөөн, уулзалтад удирдах ажилтнууд манлайлан оролцож, төрийн албан хаагчдад үлгэр дууриалал үзүүлж ажиллах		2020.12.25
5	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад холбогдох мэдээлэл, судалгааг Төрийн албаны зөвлөлд ирүүлэх	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга нар	Хууль батлагдах хүртэл хугацаанд, 2020.12.25
6	Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн ажиллах нийтлэг журмыг эрх хэмжээнийхээ хүрээнд батлан мөрдүүлэх, сургалт зохион байгуулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн дарга нар	2020.12.25
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар сургалт, соён гэгээрүүлэх ажиллагаа илүү өргөн хүрээнд тогтмол явуулах	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга нар	2020.12.25
8	Төрийн албан хаагчдад хууль тогтоомжийн хүрээнд үр дүн, хариуцлага тооцох, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж ажиллах		2020.12.25
9	Ёс зүй, ажлын хандлагыг сэтгэл зүйн тестээр шалгадаг олон улсын туршлагыг судалж төрийн албаны шалгалтад нэвтрүүлэх	Төрийн албаны зөвлөл	2020.12.25
10	Төрийн цахим харилцааны тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Мэдээллийн өгөгдөл хамгааллын тухай хуулийн төслүүдэд санал бэлтгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга нар	2020.12.25

11	Шинэ хуулийн төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмуудыг одооноос боловсруулан бэлэн болгож, хууль батлагдахад шууд хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх		2020.12.25
12	Цахим шилжилт хийх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, хамгийн сайн жишгүүдийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллах		2020.12.25

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА